

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

#### **1/29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалт:**

“29.1.4.Энэ зүйлийн 29.1.3-т зааснаас бусад тохиолдолд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд.”

#### **2/40 дүгээр зүйлийн 40.3, 40.4 дэх хэсэг:**

“40.3.Шинжээч нь Шүүх шинжилгээний тухай хуулийн 19.1-д зааснаас бусад үндэслэлээр шинжилгээ хийлгэх шийдвэрээс татгалзах эрхгүй.

40.4.Шүүх Шүүх шинжилгээний тухай хуулийн 4.1.5-д заасан мэргэжилтнийг шинжээчээр томилж болно.”

#### **3/53 дугаар зүйлийн 53.5 дахь хэсэг:**

“53.5.Энэ хуулийн 52.2.4, 52.5-д заасан нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл тодорхойгүй байна гэж үзвэл шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг тодруулахыг шаардана. Уг ажиллагааг хийсэн боловч нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл энэ хуулийн 52.5-д заасантай нийцэхгүй буюу тодорхойгүй байвал энэ хуулийн 109.2-т заасан журмаар хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.”

#### **4/116<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“116<sup>1</sup> дүгээр зүйл.** Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

116<sup>1</sup>.1.Энэ хуулийн 118.5-д заасан шүүгч хэргийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор, олон хавтастай хэргийн хувьд шаардагдах хугацаанд хавтаст хэрэгтэй танилцаж, хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэхийн тулд шүүх хуралдаанаар хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг боловсруулна.

116<sup>1</sup>.2.Шүүх бүрэлдэхүүн хэргийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор бэлтгэх ажиллагааг хийж, энэ хуулийн 116<sup>1</sup>.1-д заасан хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг батална.

116<sup>1</sup>.3.Хэрэг хуваарилагдсан шүүгч хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг боловсруулахдаа гомдол, тайлбар, тэдгээрт дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий эсэхийг хянах шаардлагад үндэслэн хэлэлцвэл зохих асуудлын жагсаалтыг дараахь байдлаар төрөлжүүлэн тодорхойлно:

116<sup>1</sup>.3.1.Шүүх хэрэг маргааныг хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэсэн эсэхийг тодруулахтай холбоотой;

116<sup>1</sup>.3.2.Шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай үйл баримтыг зохих ёсоор тогтоосон эсэх, нотлох баримтыг бүрэн, зөв үнэлсэн эсэхийг тодруулахтай холбоотой;

116<sup>1</sup>.3.3.Хэрэглэх хууль, өрсөлдөөнт хэм хэмжээг сонгохтой холбоотой;

116<sup>1</sup>.3.4.Шүүх хэрэглэвэл зохих хуулийг зөв хэрэглэж хэрэг маргааныг шийдвэрлэсэн эсэх, хуулийн албан ёсны тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахтай холбоотой;

116<sup>1</sup>.3.5.Хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хэрэглэгдэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй, харшилсан гэж үзэх үндэслэл байгаа эсэх.

116<sup>1</sup>.4.Энэ зүйлийн 116<sup>1</sup>.1-д заасан хэлэлцвэл зохих асуудлын жагсаалт нь хэргийн оролцогч хуульд заасан журмын дагуу нэмэлтээр гаргасан гомдол, тайлбарт дурдсан асуудлыг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд хязгаарлалт болохгүй.

116<sup>1</sup>.5.Энэ хуулийн 116<sup>1</sup>.2-т заасан бэлтгэх ажиллагаагаар хэргийн шийдэл, давж заалдах гомдол үндэслэлтэй эсэх талаар урьдчилсан дүгнэлт хийхгүй.

116<sup>1</sup>.6.Энэ зүйлээр тусгайлан зохицуулаагүй давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд бэлтгэх ажиллагааг Давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын журмаар зохицуулна.”

#### **5/128 дугаар зүйл:**

**“128 дугаар зүйл.Танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэй хяналтын шатны шүүх хуралдаан**

128.1.Энэ хуулийн 123.2.4-т заасан үндэслэлээр хэлэлцүүлэхээр шийдсэн хэрэг болон гурваас доошгүй шүүгч танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх санал гаргасан бол хэргийг хяналтын журмаар танхимын нийт шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ.”

#### **6/132 дугаар зүйлийн 132.6 дахь хэсэг:**

“132.6.Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш арван жил өнгөрсөн эсхүл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг адил үндэслэлээр дахин гаргасан бол хүсэлтийг хэлэлцэхгүй, буцаана.”

#### **7/135 дугаар зүйлийн 135.2 дахь хэсэг:**

“135.2.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад ажиллагааг Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу явуулна.”

#### **8/136 дугаар зүйлийн 136.2 дахь хэсэг:**

“136.2.Шүүхээс хууль бус болохыг нь нэгэнт тогтоосон шийдвэрийг агуулгаар нь дахин гаргасан бол шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцохгүй бөгөөд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх үндэслэл болно.

*Тайлбар: Шүүхээс хууль бус болохыг нь нэгэнт тогтоосон шийдвэрийн үр дагаврыг хадгалах зорилгоор өөр бусад эрх зүйн акт гаргасан, тухайлбал албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг өөрчлөх зэргээр нэхэмжлэгчийн эрхийг сэргээхгүй үр дагавартай шийдвэр гаргасан, үүний улмаас нэхэмжлэгчийн эрх зүйн байдал дээшлээгүй буюу өмнөх нөхцөл байдалтай адил байгаа тохиолдлыг ойлгоно.”*

#### **9/137 дугаар зүйл:**

##### **“137 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл**

137.1.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна.

137.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг захиргааны хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх удирдан явуулна.

137.3.Шүүхийн шийдвэр захиргааны байгууллагад ашигтайгаар гүйцэтгэгдэхээр бол Захиргааны ерөнхий хуулийн Наймдугаар бүлэгт заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

137.4.Шүүхийн шийдвэр захиргааны байгууллагын эсрэг гүйцэтгэгдэхээр бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ.

137.5.Дараах шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ:

137.5.1.хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр;

137.5.2.захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүчин төгөлдөр шүүгчийн захирамж;

137.5.3.хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол;

137.5.4.шийтгэвэр.

137.6.Дараах тохиолдолд шүүхийн шийдвэрийг нэн даруй гүйцэтгэнэ:

137.6.1.төрийн албан хаагчийг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоох тухай;

137.6.2.захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай;

137.6.3.шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацаанаас хамаарч хүн, хуулийн этгээдэд ноцтой хохирол учрахаар бол түүний хүсэлтээр;

137.6.4.хуульд заасан бусад тохиолдол;

137.7.Энэ хуулийн 137.5.1-д заасан шүүхийн шийдвэрт энэ хуулийн 106.3.4, 106.3.6, 106.3.7-д заасан шүүхийн шийдвэр хамаарна.

137.8.Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр үүрэг хүлээсэн этгээд шийдвэрт заасан хугацаанд сайн дураар биелүүлээгүй бол албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хэргийн оролцогч тухайн захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхэд гаргана.”

**10/138 дугаар зүйл:**

**“138 дугаар зүйл.Захиргааны шийдвэрийг хүчингүй болгосон, илт хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх**

138.1.Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хүчингүй болгох тухай, тэдгээрийг илт хууль бус болохыг тогтоосон тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноор маргаан бүхий шийдвэрийн эрх зүйн үйлчлэл дуусгавар болж, нэхэмжлэгчийн эрх сэргэнэ.

138.2.Шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон, илт хууль бус болохыг тогтоосон захиргааны шийдвэрийг хэрэгжүүлсний улмаас бусдад учруулсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

138.3.Хариуцагч энэ хуулийн 139.1-д заасан шийдвэрээр тодорхой үүрэг хүлээсэн боловч биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийг энэ хуульд заасан журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

138.4.Захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгосон, эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох бүртгэл хийхийг шүүгч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл хариуцсан байгууллагад үүрэг хүлээлгэнэ.”

**11/139 дүгээр зүйл:**

**“139 дүгээр зүйл.Захиргааны шийдвэр гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх**

139.1.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан захиргааны шийдвэр, үйл ажиллагааг шүүхийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 141.4-т заасан хугацаанд гаргах, хэрэгжүүлэх үүрэгтэй, уг үүргийг бүрэн хэрэгжүүлснээр шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцно.

139.2.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан үүргийг тухайн шийдвэрт, эсхүл энэ хуульд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй бол шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэнэ.”

**12/140 дүгээр зүйл:**

**“140 дүгээр зүйл.Төлбөр, хохирлын хэмжээг өөрчлөн тогтоосон, төлбөр хохирол гаргуулах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэх**

140.1.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан хугацаанд маргаан бүхий захиргааны актаар тогтоосон төлбөрийн хэмжээнд шүүхийн шийдвэрт заасны дагуу өөрчлөлт оруулна.

140.2.Маргаан бүхий захиргааны актаар тогтоосон төлбөрийг нэхэмжлэгч төлж барагдуулсан тохиолдолд шүүхийн шийдвэрээр тогтоосон зөрүүг захиргааны байгууллага нэхэмжлэгчид буцаан олгох, эсхүл дараагийн төлбөрт суутган тооцож болно.

140.3.Хариуцагч энэ хуулийн 140.1, 140.2-т заасан үүргийг зохих ёсоор биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийг энэ хууль болон Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмын дагуу албадан гүйцэтгэнэ.”

### **13/141 дүгээр зүйл:**

#### **“141 дүгээр зүйл.Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа**

141.1.Шүүгч дараах тохиолдолд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх хуудас бичнэ.

141.1.1.шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан;

141.1.2.шүүхийн шийдвэрийг нэн даруй гүйцэтгэхээр хуульд заасан;

141.2.Гүйцэтгэх хуудас нь Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

141.3.Гүйцэтгэх хуудаст энэ хуулийн 141.2-т зааснаас гадна албадан гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх хугацаа, шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, тогтоосон хугацааны дотор шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд авах албадлагын арга хэмжээ болон хүлээлгэх хариуцлагын талаар тусгана.

141.4. Шүүгчийн туслах нь гүйцэтгэх хуудас бичигдсэнээс хойш 3 хоногийн дотор шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас, шаардлагатай бусад баримт бичгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад, шүүхийн мэдэгдлийг шийдвэрийг гүйцэтгэвэл зохих этгээдэд хүргүүлнэ.

141.5.Гүйцэтгэх хуудсыг хүлээн авсан шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх байгууллага түүнийг үл маргалдах журмаар тэр даруй биелүүлнэ.

141.6.Шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх хуудсыг хүлээн авмагц холбогдох этгээдэд шүүхийн шийдвэр албадан гүйцэтгэх ажиллагаа эхэлснийг мэдэгдэж, шүүхийн шийдвэр биелүүлэх 20 хүртэл хоногийн хугацаа олгоно.

141.7.Мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч уг хугацаа дууссанаас хойш 3 хоногийн дотор албадлагын арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг шүүхэд хүргүүлнэ.

141.8.Нэн даруй биелүүлэх шүүхийн шийдвэрийг дараах журмын дагуу гүйцэтгэнэ.

141.8.1.Энэ хуулийн 137.6-д заасан шийдвэр гаргасан шүүгч 141.1.2-т зааснаар шүүхийн шийдвэрийн хамт гүйцэтгэх хуудас бичиж, шийдвэр гүйцэтгэгчид, энэ талаарх шүүхийн мэдэгдлийг холбогдох этгээдэд тус тус хүргүүлнэ.

141.8.2.Шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх хуудсыг хүлээн авмагц холбогдох этгээдэд шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусахад сайн дураар биелүүлээгүй бол албадан гүйцэтгэх ажиллагаа шууд эхлэх талаар мэдэгдэнэ. Мэдэгдэлд шүүхийн шийдвэр биелүүлэх 7 хүртэл хоногийн хугацаа олгоно.

141.8.3.Мэдэгдэлд заасан хугацаанд шүүхийн шийдвэр биелэгдээгүй бол шийдвэр гүйцэтгэгч уг хугацаа дууссанаас хойш 1 хоногийн дотор албадлагын арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг шүүхэд хүргүүлнэ.

141.9.Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд тухайн актын агуулгаас хамаарч шийдвэр гүйцэтгэгч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

141.9.1.тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид болон үүрэг хүлээсэн гуравдагч этгээдэд даалгах;

141.9.2. Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу эд хөрөнгийг битүүмжлэх;

141.9.3.Энэ хуулийн 141.9.1, 141.9.2-т заасан шийдвэр гүйцэтгэгчээс өгсөн үүргийг зөрчсөн буруутай этгээдэд албадлагын арга хэмжээ авах хүсэлтийг шүүхэд хүргүүлэх.”

#### **14/142 дугаар зүйл:**

#### **“142 дугаар зүйл.Албадлагын арга хэмжээ**

142.1.Шүүгч шийдвэр гүйцэтгэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй шалтгааныг судлан үзэж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хариуцагчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль оногдуулсан захирамж гаргаж, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ.

142.2.Хариуцагч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй нь тогтоогдвол сайн дураар биелүүлэх хугацааг шүүгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.

142.3.Албадлагын арга хэмжээ ногдуулсан захирамжид хэрэгжих хугацааг 14 хүртэл хоногоор тогтоох бөгөөд торгуулийн хэмжээг тогтоохдоо шүүгч хариуцагчийн санхүүгийн болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

142.4.Шүүгчийн захирамжийг хүлээн авсан даруй шийдвэр гүйцэтгэгч албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төлбөр гаргуулах журмын дагуу захирамжид заасан хугацааны дотор хэрэгжүүлнэ.

142.5.Албадлагын арга хэмжээ авагдсан боловч энэ хуулийн 142.3-т заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй хариуцагчид тухайн албадлагын арга хэмжээг шүүгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүртэл хэдэн ч удаа ногдуулж болно.

142.6.Албадлагын арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж гарсны дараа хариуцагч шүүхийн шийдвэрийг биелүүлбэл хамгийн сүүлд ногдуулсан торгуулийн төлбөрийг хариуцагчаас гаргуулахгүй байж болно.

142.7.Энэ хууль болон Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нийтлэг болон тусгай журмын дагуу явуулсан захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргахгүй. Хохирол гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэр гүйцэтгэлийг хариуцаж буй шүүгч Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 13-19 дүгээр зүйлд заасан журмыг төсөөтэй хэрэглэн шийдвэрлэнэ.

142.8.Хохирол гаргуулах шийдвэр гүйцэтгэх явцад гаргасан эд хөрөнгөөс төлбөр гаргуулах албадлагын арга хэмжээтэй холбогдох шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүгчид хандаж, гомдол гаргаж болно. Уг гомдлыг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, тогтоолыг эс зөвшөөрвөл захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.”

#### **15/143 дугаар зүйл:**

#### **“143 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага**

143.1.Шүүхийн шийдвэрийг биелүүлэлгүй хоёр буюу түүнээс дээш удаа албадлагын арга хэмжээ авагдсан хариуцагчид шүүгч Төрийн албаны тухай болон холбогдох хуульд заасан сахилгын шийтгэлийг ногдуулахаар эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлнэ.

143.2.Энэ хуулийн 143.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан, байгууллага мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хуульд заасан сахилгын шийтгэлийг шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд ногдуулж, энэ тухай шүүхэд мэдээлнэ.

143.3.Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүйн улмаас сахилгын шийтгэл хүлээсэн нь тухайн албан тушаалтныг шүүхийн шийдвэр биелүүлэх энэ хуульд заасан албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

143.4.Энэ хуульд заасан албадлагын арга хэмжээ авагдсан, хариуцлага хүлээсэн нь шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулсан этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхэд саад болохгүй.

143.5.Энэ хуулийн 143.4, Захиргааны ерөнхий хуулийн Наймдугаар бүлэгт заасны дагуу шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтны мэдээллийг шийдвэр гүйцэтгэлийг хариуцаж буй шүүхийн бүртгэлд бүртгэж, тухайн шүүхийн цахим санд олон нийтэд байршуулна.”

#### **16/112 дугаар зүйлийн 112.1.5 дахь заалтын тайлбар:**

*“Тайлбар: Монголбанкнаас гаргасан шийдвэр гэдэгт Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Монголбанкны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд гаргасан шийдвэрийг ойлгоно.”*

**2 дугаар зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “заасан” гэсний дараа “захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанаас бусад” гэж, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийн “123.7” гэсний дараа “142.8” гэж, 122.6 дахь хэсгийн “бүрэлдэхүүнтэйгээр” гэсний дараа “зөвлөлдөн” гэж, 123 дугаар зүйлийн 123.6 дахь хэсгийн “тохиолдолд” гэсний дараа “нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаас бусад хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх бөгөөд” гэж, 127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсгийн “хэргийг” гэсний дараа “энэ хуулийн 128 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэг:**

“53.3.Нэхэмжлэл нь энэ хуулийн 52.2.4, 52.5-д зааснаас бусад 52.2, 52.3-т заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно.”

**2/118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэг:**

“118.5.Тухайн хэрэг хуваарилагдсан шүүгч шүүх хуралдаанд бэлтгэх ажиллагааг эрхлэн явуулна.”

**3/123 дугаар зүйлийн 123.4 дэх хэсэг:**

“123.4.Хяналтын журмаар гаргасан гомдолд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, гомдлыг энэ хуулийн 119.5-д заасан хугацаанд гаргасныг нотлох баримт, гомдол гаргах эрхтэй этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.”

**4/135 дугаар зүйлийн 135.1 дэх хэсэг:**

“135.1.Хэргийн оролцогчид шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд сайн дураар бүрэн биелүүлэх үүрэгтэй бөгөөд биелүүлээгүй тохиолдолд энэ хуульд заасан журмын дагуу албадан биелүүлнэ.”

**5/136 дугаар зүйлийн 136.1 дэх хэсэг:**

“136.1.Хариуцагч шүүхийн шийдвэрт заасан захиргааны акт, захиргааны хэм хэмжээний актыг гаргах, захиргааны гэрээ байгуулах, эсхүл шүүхийн шийдвэр, мэдэгдэлд заасан үүргийг тогтоосон хугацаанд, зохих ёсоор бүрэн биелүүлсэн бол шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцно.”

**4 дүгээр зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.4.3 дахь заалтын “маргаан” гэснийг “маргаанд өөрт нь тусгай хугацаа заагаагүй бол” гэж, 112.6 дахь хэсгийн “30 хүртэл хоногоор” гэснийг “15 хүртэл хоногоор” гэж, 113 дугаар зүйлийн 113.5 дахь хэсгийн “магадлалд хяналтын” гэснийг “шийдвэрт давж заалдах” гэж, 118 дугаар зүйлийн 118.7 дахь хэсгийн

“Илтгэгч шүүгчээс нэхэмжлэлийн шаардлага, анхан шатны шүүхийн шийдвэрийн агуулга, давж заалдах гомдлын үндэслэлийг танилцуулж” гэснийг “Энэ хуулийн 118.5-д заасан шүүгчээс гомдол гаргагч шүүх хуралдаанд оролцоогүй бол давж заалдах гомдлын үндэслэлийг танилцуулж” гэж, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсгийн “114 дүгээр зүйлд заасан ажиллагааг гүйцэтгэнэ.” гэснийг “123.4-т заасан бүрдлийг шалгана.” гэж, 124.2 дахь хэсгийн “хэрэгт улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, хэргийн оролцогчдын гомдлыг хавсарган” гэснийг “энэ хуулийн 123.4-т заасан баримтын хамт” гэж, 136 дугаар зүйлийн гарчгийг “Шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцох” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.6 дахь хэсгийн “илтгэгч шүүгчээс хэргийн талаар танилцуулах хүртэл” гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.**Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.8 дахь хэсэг, 112 дугаар зүйлийн 112.1.4 дэх заалт, 112.11 дахь хэсэг, 113 дугаар зүйлийн 113.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8.12 дахь заалтыг нэмсүгэй:

“25.8.12.хяналтын шатны шүүх хуралдааны дэгийг батлах.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг